



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.б дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан нийт 31,326,785,665.00 (гучин нэгэн тэрбум гурван зуун хорин зургаан сая долоон зуун наян таван мянга зургаан зуун жаран таван) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001119

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны  
өдрийн 07 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН, ТӨРИЙН ӨМЧИД  
БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Барилга байгууламж /хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ/-ний нэр	Ашигла лтад орсон он	Хөрөнгийн нийт үнэ (төгрөг)	Хүлээн авах байгууллага
1	Орхон, Баян-Өндөр сум Дөмөг захын уулзвараас 6 дугаар хороолол хүртэлх авто замын өргөтгөл, 2.1 км	2021	5,714,514,789.00	Зам, тээврийн хөгжлийн яам
2	Ховд аймгийн Булган-Үенч-Ховд чиглэлийн 60 км хатуу хучилттай авто зам	2020	25,612,270,876.00	Зам, тээврийн хөгжлийн яам
			31,326,785,665.00	
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		31,326,785,665.00 (гучин нэгэн тэрбум гурван зуун хорин зургаан сая долоон зуун наян таван мянга зургаан зуун жаран таван)	